

2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/26

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүн түр томилох тухай

Компанийн тухай хуулийн 77.5, 77.6, компанийн дүрмийн 8.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ЗНДЦУ-ын хорооны зөвлөмж, ТУЗ-ийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын иргэн Роланд Нэшийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нөхөн сонгууль хүртэл ТУЗ-ийн гишүүнээр түр томилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх, бүртгүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2023 | 10 | 26

No 23/26

Ulaanbaatar

The Board of Directors' Resolution

Appointment of an Interim Board Member

Pursuant to Articles 77.5 and 77.6 of the Company Law, Clause 8.3 of the Charter of Company, the recommendations of the Board of Directors' GNR Committee, and the decision made at the ordinary meeting of the Board of Directors on October 26, 2023, it is hereby RESOLVED:

1. To appoint Mr. Roland Nash, a citizen of the United Kingdom of Great Britain and Northern Ireland, as an interim member of the Board of Directors until the next board election.
2. To instruct the Secretary of the Board of Directors to oversee the execution of this resolution and to formally notify and register the change with the appropriate authorities.

CHAIRMAN



GANHUYAG CH.

2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/28

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ард Лизинг ХХК-д хөрөнгө шилжүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.17, компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК 18 тэрбум хүртэлх төгрөгийн үнэлгээ бүхий эдийн бус хөрөнгийг өөрийн охин компани Ардлизинг ХХК-д шилжүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолд заасан санхүүжилтийг компани хөрөнгө оруулалтаар бүртгэж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгийг шилжүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2023 | 10 | 28

No 23/28

Ulaanbaatar

The Board of Directors' Resolution

Capitalization of Ard Leasing

Pursuant to Articles 62 and 76, Clause 76.1.17 of the Company Law, the Charter of Company, and the decision made at the ordinary meeting of the Board of Directors on October 26, 2023, it is hereby RESOLVED:

1. To transfer intangible assets valued at a maximum of 18 billion MNT from Ard Financial Group JSC to its subsidiary, ArdLeasing LLC.
2. To direct the acting CEO (Zolboo B.), to officially categorize this transfer as an investment and proceed with the asset transfer in strict compliance with all relevant laws and regulations.

CHAIRMAN



GANHUYAG CH.

2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 25/29

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*"Kingsway FCI Co-Investment SPC" санд
хөрөнгө оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Хөрөнгө оруулалт, эрсдлийн хорооны зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК "Kingsway FCI Co-Investment SPC" санд 100,000 долларын хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэлд компанийг төлөөлж гарын үсэг зурах, хөрөнгө оруулалт баталгаажснаас хойш эрсдэлийг тооцон зайлшгүй нөхцөлд хойшлуулшгүй арга хэмжээ авч ажиллахыг тус тус гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2023 / 10 / 26

No 25/25

Ulaanbaatar

The Board of Directors' Resolution

*To approve the investment into TON
by telegram through private equity*

Pursuant to Article 76 of the Company Law, the recommendations of the Board of Directors' IR Committee, and the decision made at the ordinary meeting of the Board of Directors on October 26, 2023, it is hereby RESOLVED:

1. To approve an investment of USD 100,000 by Ard Financial Group JSC in Kingsway FCI Co-Investment SPC.
2. To direct the acting CEO (Zolboo B.) to ensure the implementation of this resolution, sign the relevant contracts on behalf of the company, and promptly take measures considering the risks after the investment is confirmed.

CHAIRMAN



GANHUYAG CH.

2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/30

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Хөрөнгө оруулалт, эрсдэлийн хороо, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөрөнгийн зах зээл, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан компани Ард секюритиз УЦК, Ард лизинг ХХК, Ардын тэтгэврийн данс ХХК, Ард бит ХХК нараас хувьцаагаа эргүүлэн худалдан авах шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б. Золбоо)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2023 | 10 | 26

No 23/30

Ulaanbaatar

The Board of Directors' Resolution

To cancel the share buyback program

Pursuant to Article 76 of the Company Law, the recommendations of the Board of Directors' IR Committee, and the decision made at the ordinary meeting of the Board of Directors on October 26, 2023, it is hereby RESOLVED:

1. To refrain from implementing the share buyback program based on prevailing stock market and economic conditions.
2. To direct the acting CEO (Zolboo B.) to implement this resolution and to deliver the relevant information to the authorities.

CHAIRMAN



GANHUYAG CH.

2023 он 10 сар 26 өдөр

Дугаар 23/31

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, ТУЗ-ийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024-2026 оны стратеги төлөвлөгөө (OGSM)-г тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн үйл ажиллагааны төсөв төлөвлөгөөг баталж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2023, 10, 26

No 23/21

Ulaanbaatar

The Board of Directors' Resolution

Approval of OGSM

Pursuant to article 76 of the Company Law and decision made at the ordinary meeting of the Board of Directors on October 26, 2023, it is hereby RESOLVED:

1. To approve the "The company's strategic plan for 2024-2026 (OGSM)" as an appendix of this resolution.
2. The implementation of this resolution shall be the responsibility of the Board of Directors. The CEO shall be responsible for the implementation of the procedure and the day-to-day management of the company's operations.

CHAIRMAN



GANHUYAG CH.